

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/21/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг:
ariuntuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГА М.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/286
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ТТЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд барилга, байгууламж 98.0 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 29.5 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 78.6 сая төгрөгөөр, нийт 206.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 24.0 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос 21.5 сая төгрөг нийт 45.5 сая төгрөгийн орлого тасарсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон 12 зээлдэгчтэй холбоотой 29.7 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Шинэ-Идэр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 3 зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 98.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5724040720

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		406,182.80	313,240.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	205,507.00	131,813.90
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	123,816.30	98,597.10
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	76,859.50	82,829.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,167,819.40	2,279,275.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0	122,000.00
37300	Урт хугацаат зээл		0	122,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,167,819.40	2,157,275.60
39200	Биет хөрөнгө		2,124,502.90	2,114,701.80
39300	Биет бус хөрөнгө	13	43,316.60	42,573.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,574,002.20	2,592,516.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,680.00	7,817.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,680.00	7,817.70
41300	Өглөг	17а, 17б	5,680.00	7,817.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,568,322.20	2,584,698.70
51	Засгийн газрын хувь оролцоо		2,568,322.20	2,584,698.70
51200	Хуримтлагдсан үр дүн		378,427.30	394,803.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,574,002.20	2,592,516.40

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		915,947.2	1,589,911.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		306,891.1	342,199.6
110	Орлогын албан татвар		228,873.5	241,282.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		243,779.8	266,681.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-14,906.3	-25,398.5
113	Хөрөнгийн албан татвар		46,666.4	51,584.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		31,351.2	49,332.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	-331,487.5	100,282.5
120	Нийтлэг татварын бус орлого		-331,487.5	100,282.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		940,543.5	1,147,429.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	969,090.4	1,573,535.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		969,090.4	1,573,535.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		929,283.3	1,550,978.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		382,207.2	472,790.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		47,986.6	61,630.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		74,623.1	45,467.9
2104	Хангамж, бараа материалын зардал		25,558.9	93,110.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		24,669.4	4,000.0
2107	Томиллолт, зочны зардал		2,673.0	4,306.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		93,706.6	642,781.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		277,858.5	226,891.2

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		39,807.1	22,557.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-53,143.2	16,376.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-10,022,504.9	16,376.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,400,290.2	2,067,720.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	306,891.1	342,199.6
110	Орлогын албан татвар	228,873.5	241,282.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	243,779.8	266,681.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,906.3	-25,398.5
113	Хөрөнгийн албан татвар	46,666.4	51,584.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	31,351.2	49,332.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,221.4	6,374.4
1181	Газрын төлбөр	2,201.4	2,765.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,928.4	40,192.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,855.6	578,091.0
120	Нийтлэг татварын бус орлого	152,855.6	578,091.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	940,543.5	1,147,429.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,392,936.4	1,987,330.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,392,936.4	1,987,330.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,092,718.1	1,712,260.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	543,661.0	651,935.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,785.4	114,476.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,928.7	146,178.0
2104	Хангамж, бараа материалын зардал	174,561.8	158,410.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,669.4	4,000.0
2107	Томилолт, зочны зардал	2,673.0	4,306.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,893.2	603,649.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,545.6	29,305.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,218.3	275,069.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,353.9	80,389.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	66,822.0	32,083.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,822.0	32,083.0
2200	Дотоод эх үүсвэрээр	66,822.0	32,083.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-66,822.0	-32,083.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-122,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	122,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-59,468.1	-73,693.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	264,975.1	205,507.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205,507.0	131,813.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,668,362.0	12,668,362.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-72,577.4	-72,577.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,595,784.6	12,595,784.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-4,957.5	-4,957.5
9	Тайлант үеийн үр дүн	-10,022,504.9	-10,022,504.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,568,322.2	2,568,322.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,568,322.2	2,568,322.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,568,322.2	2,568,322.2
19	Тайлант үеийн үр дүн	16,376.5	16,376.5
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,584,698.7	2,584,698.7

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,659,248.30	1,598,982.84	60,265.46	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,529,248.30	1,476,982.84	52,265.46	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,239,471.00	1,210,319.84	29,151.16	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,768.50	472,790.50	8,978.00	98.1
210101	Үндсэн цалин	334,792.00	331,261.35	3,530.65	98.9
210102	Нэмэгдэл	140,576.50	135,662.85	4,913.65	96.5
210104	Урамшуулал	6,400.00	5,866.30	533.70	91.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,475.90	61,630.72	1,845.18	97.1
210201	Тэтгэврийн даатгал	41,992.40	41,992.40	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,913.50	5,782.17	131.33	97.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,155.40	3,622.41	532.99	87.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,038.80	830.76	208.04	80.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,375.80	9,402.99	972.81	90.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	543,181.80	533,903.14	9,278.66	98.3
210301	Гэрэл, цахилгаан	31,357.00	24,087.00	7,270.00	76.8
210302	Түлш, халаалт	506,091.80	506,083.13	8.67	100.0
210303	Цэвэр, бохир ус	5,733.00	3,733.00	2,000.00	65.1
2104	Хангамж, бараа материалын зардал	33,900.10	32,590.08	1,310.02	96.1
210401	Бичиг хэрэг	3,000.00	3,000.00	-	100.0

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	25,392.10	25,391.18	0.92	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,816.00	2,599.40	1,216.60	68.1
210404	Ном, хэвлэл	392.00	299.50	92.50	76.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300.00	1,300.00	-	100.0
2105	Нормативт зардал	1,450.00	-	1,450.00	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,450.00	-	1,450.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,599.50	29,596.50	3.00	100.0
210604	Урсгал засвар	29,599.50	29,596.50	3.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,900.00	4,306.00	594.00	87.9
210702	Дотоод албан томилолт	4,900.00	4,306.00	594.00	87.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,591.30	46,197.90	4,393.40	91.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,941.30	44,093.51	3,847.79	92.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700.00	550.00	150.00	78.6
210803	Даатгалын үйлчилгээ	1,000.00	920.50	79.50	92.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240.00	123.50	116.50	51.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.00	99.00	1.00	99.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260.00	260.00	-	100.0
210807	Газрын төлбөр	350.00	151.39	198.61	43.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,603.90	29,305.00	1,298.90	95.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,103.90	24,100.00	3.90	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,500.00	5,205.00	1,295.00	80.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	289,777.30	266,663.00	23,114.30	92.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	274,565.20	252,512.40	22,052.80	92.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	274,565.20	252,512.40	22,052.80	92.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,212.10	14,150.60	1,061.50	93.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,000.60	13,000.60	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,211.50	1,150.00	1,061.50	52.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	130,000.00	122,000.00	8,000.00	93.8
230001	Эргэж төлөгдөх зээл	130,000.00	122,000.00	8,000.00	93.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,659,248.30	1,523,431.36	135,816.94	91.8

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	194,852.10	191,852.10	3,000.00	98.5
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	194,852.10	191,852.10	3,000.00	98.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,265,147.70	1,302,263.51	(37,115.81)	102.9
320001	Орон нутгийн төсвөөс	1,265,147.70	1,302,263.51	(37,115.81)	102.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	199,248.50	29,315.75	169,932.75	14.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	24,820.99	25,179.01	49.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	149,248.50	-	149,248.50	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	46	46	-	46.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	-	22.0
620001	Удирдах ажилтан	8	8	-	8.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	12.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	22	-	22.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	-	10.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	5.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	-	7.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,346,726.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,346,726.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,346,726.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,369,000.00
210401	Бичиг хэрэг	69,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,977,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,977,726.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,346,726.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,346,726.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,867,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,479,726.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ОНӨААН, нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийг урт болон богино хугацаагаар нь ангилан нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 122.0 сая төгрөгийг аудитын хугацаанд залруулж ажилласан.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 76.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Шинэ-Идэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилгүй байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Аудитын илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 12 зээлдэгчтэй холбоотой 29.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1. "орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн орлого 6 нэр төрлийн 24.0 сая төгрөгийн орлогоор, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 2 нэр төрлийн 21.5 сая төгрөгийн орлогоор, нийт 45.5 сая төгрөгийн орлого тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь гүйцэтгэлийг хангаж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

				/сая төгрөгөөр/	
	Нийт алдаа			Үүнээс	Зөвлөмж

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Алдааны товч утга			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байдлын тайланд Урт хугацаат хөрөнгө оруулалтыг Авлага дансанд бүртгэсэн	1	122.0			1	122.0	1	122.0				
Дүн	1	122.0			1	122.0	1	122.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	45.5					1	45.5				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	29.7					1	29.7				
Дүн	2	75.2					2	75.2				